



БЭЭЛГИЙН ЗАМААР ДАМЖИХ ХАЛДВАРУУДЫН ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ

З.Сэцэн

АУ-ны магистр,

БЗДХ, ХДХВ, ДОХ-ын


ЭМЧ

2022 он

БЗДХ-УУДЫН ЕРӨНХИЙ

СЭРГИЙЛГЭЭ ОЙЛГОЛТ

- Тойм
- Эмчилгээ
- Урьдчилан сэргийлэлт




Нэг хүнээс нөгөө
хүнд бэлгийн
хавьтлаар дамждаг
халдварыг бэлгийн
замаар дамжих
халдвар гэдэг.

БЭЛГИЙН ХАВЬТЛЫН ТӨРЛҮҮД

Үтрээгээр

Амаа
р

Шулуун
гэдсээр



Зарим БЗДХ-ууд мөн өөр замаар халдварлах боломжтой байдаг.

цус, цусан бүтээгдэхүүн, бохирлогдсон зүү тариур, эмнэлгийн багаж хэрэгслээр

Эхээс хүүхдэд жирэмсэн, төрөх, хөхүүл үед

Арьсаар хүрэлцэх хавьтлын үед

БЗДХ-ЫН ҮҮСГЭГЧ

Нийт 30 гаруй төрлийн вирус, нян, шимэгчид БЗДХ-ыг үүсгэдэг нь тогтоогдсон байдаг.


Нян: Хламид, заг хүйтэн, тэмбүү

Вирус: Бэлгийн үү, бэлгийн херпес, ХДХВ-ийн халдвар, гепатит А, В, С вирусийн халдвар, халдварт моллюск

Эгэл биетэн: Хамуу, бөөс, трихомониаз

Мөөг: Мөөгөнцөр

WHEN TO GET TESTED



GONORRHEA
2 to 30 days
after exposure



TRICHOMONIASIS
5 to 28 days
after exposure



CHLAMYDIA
1 to 3 weeks
after exposure



SYPHILIS
10 days to 3 months
after exposure



HERPES
2 weeks to 3 months
after exposure



HEPATITIS B
3 weeks to 2 months
after exposure




HIV
4 weeks to 3 months
after exposure



HEPATITIS C
anytime up to 6 months
after exposure

healthline

Монголд гей, бисекс болон бусад эрчүүдтэй бэлгийн хавьталд ордог эрчүүдийн дундах зарим БЗДХ-ын тархалт (%)



ТОО МЭДЭЭ

Дэлхий дээр жил бүр **374** сая хүн хламид, заг хүйтэн, тэмбүү, трихомониаз хэмээх дөрвөн БЗДХ-ын аль нэг халдварыг шинээр авдаг гэсэн тооцооллыг ДЭМБ-аас гаргасан байна. Монгол улсад 2021 оны эцсийн байдлаар трихомониаз, тэмбүү, заг хүйтний өвчлөлийг авч үзэхэд, сүүлийн 10 жилийн хугацаанд жил бүр дунджаар **13560** хүн дээрх БЗДХ-ын аль нэгээр өвчилсөн байна.

ДЭМБ-ын мэдээлснээр өдөрт
дунджаар 1 сая хүн БЗДХ авдаг
бөгөөд тэдний дийлэнх нь шинж
тэмдэггүй байдаг ажээ.

Гей, бисекс эрэгтэйчүүдийг

6 сар тутам

БЗДХ, ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээнд хамрагдахыг зөвлөдөг.




ЭМЧИЛГЭЭ


БЗДХ илэрсэн бол мэргэжлийн
эмчид хандан эмчилгээ хийлгэж,
өөрийн эрүүл мэндийг
хамгаалаарай!

ЭМЧИЛГЭЭНД АНХААРАХ ЗҮЙЛС:


Танд шинж тэмдэг илрээгүй ч шинжилгээгээр БЗДХ илэрсэн бол эмчилгээ хийлгэх шаардлагатай. Учир нь БЗДХ-ын үед ямар ч шинж тэмдэг илрэхгүй байх нь түгээмэл.



Бэлгийн хавьтагчдыг зэрэг эмчилэх нь таныг дахин халдвар авахаас сэргийлнэ.



Шинж тэмдэг арилсан ч эмчилгээг бүрэн дуусгах нь зүйтэй. Ингэснээр ирээдүйд учирч болох хүндрэлээс сэргийлж чадна.



Эмчилгээний үед бэлгийн хавьталд орохгүй байх, мөн алкоголь хэрэглэхгүй байх нь зүйтэй.

Дийлэнх БЗДХ-ын шалтгаан нь доорх 8 үүсгэгч байдаг.

Бүрэн эмчлэгддэг

тэмбүү
заг хүйтэн,
хламид,
трихомониаз

Бүрэн эмчлэгддэггүй


гепатит В вирус,
энгийн херпес вирус,
хүний дархлал хомсдолын вирус,
хүний хөхөнцөр вирус

'SUPERBUG'

Заг хүйтний “супер нян” дэлхийн олон оронд бүртгэгдээд байна.



Гонококкын эмэнд тэсвэржилтийн тандалт сайн хөгжсөн орнуудын тоо мэдээнээс үзэхэд антибиотик мэдрэг чанар багасч, сүүлчийн сонголтын (цефтриаксон, азитромицин) эмэнд тэсвэржилт нэмэгдсээр байна.



Эмчлэгдээгүй заг хүйтэн нь ХДХВ-ийн халдвар авах эрсдлийг 5 дахин нэмэгдүүлдэг.

Манай улсад бүртгэгдсэн ХДХВ-ийн

халдварын


99.7%

бэлгийн замаар халдвар дамжсан байна.

**ХДХВ-ийн халдвар нь бүрэн төгс
эдгэрдэггүй боловч эмчилгээтэй
архаг халдварын тоонд ордог.**

ХДХВ, ДОХ-той хүн насан туршдаа эм хэрэглэн, урт
удаан, чанартай амьдралаар амьдарч байна.

ViiV HEALTHCARE'S APPROACH TO HIV CURE (INDUCE AND REDUCE)



Эсэд халдварлан, нуугдсан ХДХВ нь энэ халдварыг бүрэн төгс эмчлэхэд учирч буй гол саад бэрхшээл бөгөөд эсийн дотор нуугдсан тэдгээр унтаа ХДХВ-ийг хэрхэн устгах боломжийг эрдэмтэд эрчимтэй судалж байна.

nature

Explore content ▾ About the journal ▾ Publish with us ▾ Subscribe


[nature](#) > [news & views](#) > article

NEWS AND VIEWS | 14 December 2020


Viruses, microscopy and fast radio bursts: 10 remarkable discoveries from 2020

Эрдэмтэд эрүүл эсүүдэд харьцангуй бага нөлөөлөлтэйгөөр унтаа ХДХВ-ийг идэвхжүүлэн, устгах боломжийг судалсан нь Nature сэтгүүлийн 2020 оны шилдэг 10 нээлтэд багтсан.


БЗДХ-ААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГУУД




Төгс сэргийлэх арга бол бэлгийн хавьтлаас зайлсхийх байдаг.




Зарим бэлгийн замаар дамждаг вирусийн халдвараас вакцины тусламжтай сэргийлэх боломжтой: HPV, HBV.



Бэлгийн хавьтагчдынхаа тоог багасгахад БЗДХ авах эрсдэл дагаад буурдаг.



Хоёр талын моногам харилцаа нь хамгийн найдвартай аргын нэгд тооцогддог.



Эрэгтэй латексан бэлгэвчийг үтрээ, шулуун гэдэс, амаар секс хийх бүртээ тогтмол, зөв хэрэглэх нь БЗДХ-аас маш үр дүнтэй сэргийлдэг.

ТА ӨӨРИЙН ЭРСДЭЛ, ЗАН ҮЙЛ,
АМЬДРАЛЫН ХЭВ МАЯГТАА
ТОХИРУУЛАН, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ
АРГУУДЫГ ХОСЛУУЛАН ХЭРЭГЛЭХ НЬ ҮР
ДҮНТЭЙ.

Урьдчилан сэргийлэх хамгийн шилдэг арга нь амьдралын хэв
маягийн нэг хэсэг болж чадах тэр арга юм.

ТА БЗДХ-ЫГ

бэлгийн хавьталд анх орохдоо

хамтрагчаа сайн мэддэг байсан

ч

аман секс хийгээд

олон удаа давтан

нэг дор олон төрлийн халдвар
авах боломжтой.

Хэн нэгнийг гаднаас нь хараад БЗДХ-тай эсэхийг мэдэх боломжгүй.

БАЯРЛАЛАА